МЭДЭЭ · 2023 оны 6-р сарын 7

ТАВДУГААР САРД ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ГАРАЛТ БУУРЧЭЭ

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

ЗӨРЧЛИЙН ТООН МЭДЭЭ

2023.05.01-2023.06.01

Нийт зөрчил 1.238.126 17.3%↓

Нийслэлд 895.182

Орон нутагт 342.944

Цагдаа	187.090
Гаалийн байгууллага	301
Татварын байгууллага	181
Гадаадын иргэн, харьяатын газар	631
Онцгой байдлын газар	61
Бусад	6592

Зөрчлийн улмаас учирсан хохирол 2.317.586.000 төгрөг

Төлөгдсөн хохирол 1.182.331.000 төгрөг

Шийтгүүлсэн хүн 186.938

Хуулийн этгээд 575

147.168

39.773

16-18 нас	334	36-45 нас	55.459
18-25 нас	24.503	46-55 нас	27.845
26-35 нас	65.793	56-аас дээш нас	12.395

Буурсан зөрчил

Татварын хууль зөрчих	94
Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх	94
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	160.540

Өссөн зөрчил

Гаалийн тухай хууль	14.732
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	804
Хүүхдийн эрхийг зөрчих	405
Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих	70

prokuror.mn

Улсын хэмжээнд 2023 оны 5 дугаар сарын байдлаар 1.238.126 зөрчлийн хэрэг бүртгэгдсэн нь 4 дүгээр сартай харьцуулахад 17.3 хувиар буурсан байна.

Нийт зөрчлийн хэргийн 72.3 хувь нь Нийслэлд, 27.6 хувь нь орон нутагт бүртгэгдсэн бол 95.8 хувийг Цагдаагийн байгууллага, 4.2 хувийг бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд шалгаж шийдвэрлэжээ.

Дээрх хугацаанд 186.938 хүн, 575 хуулийн этгээд Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгүүлсэн ба өмнөх сараас шийтгэл оногдуулсан хүн 18.1 хувиар буурч, хуулийн этгээд 22.3 хувиар өссөн байна.

Зөрчил үйлдсэн хүмүүсийн 78.7 хувь нь эрэгтэй, 21.2 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол дийлэнх буюу 64.8 хувь нь 26-45 насныхан байна.

Өнгөрсөн тавдугаар сард үйлдэгдсэн зөрчлийг дөрөвдүгээр сартай харьцуулахад Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих зөрчил 20.7 хувиар, Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил 13.4 хувиар, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих 4.3 хувиар тус тус өссөн байна.

Харин Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 19.5 хувиар, Татварын хууль зөрчих зөрчил болон Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчил тус бүр 5.1 хувиар буурчээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1911